# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ГСА-2024/46/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Говьсүмбэр аймаг<br>2024 он | Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: Д.Сарантуяа<br>Утас: 70543179<br>Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn<br>Аудитын менежер: Г.Наранбаяр<br>Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn<br>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн:<br>Баталгаат тооцоолол аудитХХК-ийн<br>Захирал: М.Буянбулган<br>Утас: 77153069<br>Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com<br>Чанарын менежер: Г.Цогтбаатар<br>Аудитор: Н.Цэнгэнбаяр |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 10

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 10

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 12

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 12

3.5.1 Төсвийн төлөвлөлт ........ 13

3.5.2 Төсвийн гүйцэтгэл ........ 13

3.5.3 Нэмэлт төсөв ........ 13

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ........ 13

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл ........ 13

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 14

4.1 Ерөнхий зүйл ........ 14

4.2 Материаллаг байдал ........ 14

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 14

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 15

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15

4.5.1 Завсрын аудитын талаар ........ 15

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ........ 15

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 16

5.1 Зөвлөмж ........ **16**

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БХНСАХЗ | Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал |
| ГСА | Говьсүмбэр аймаг |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МУЕА | Монгол улсын ерөнхий аудитор |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс:976-7054 3179
И-мэйл: govisumber@audit.gov.mn

2024.02.23 № 37

танай ______________-ны № ______________-т

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ Д.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тайлант онд 12 зорилтын хүрээнд 141 арга хэмжээг хэрэгжүүлж 95.0 хувиар гүйцэтгэсэн гэж тайлагнасныг аймгийн Засаг дарга 91.0 хувийн биелэлттэй дүгнэсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.САРАНТУЯА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **159,045,565.00** | **90,856,638.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 7,101,190.00 | 12,539,590.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **7,101,190.00** | **12,539,590.00** |
| 31213 | Нөөц харилцах ахмад | 7,101,190.00 | 12,539,590.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **151,944,375.00** | **78,317,048.00** |
| **351** | **Түүхий эд материал** | **27,180,000.00** | **39,953,280.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 27,180,000.00 | 39,953,280.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **31,142,324.00** | **38,363,768.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,165,100.00 | 5,626,240.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,025,170.00 | 3,139,650.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,939,250.00 | 65,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 201,532.00 | 456,146.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 21,811,272.00 | 29,076,732.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | **93,622,051.00** | **0.00** |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **428,663,695.13** | **682,277,407.99** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 428,663,695.13 | 682,277,407.99 |
| **392** | **Биет хөрөнгө** | **91,441,663.33** | **345,957,386.79** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,500,000.00 | 284,874,068.18 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (544,444.32) | (39,682,509.24) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 14,200,000.00 | 18,800,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (10,086,666.72) | (14,455,555.56) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 28,536,637.00 | 67,583,737.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (18,902,829.82) | (18,328,620.28) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 7,189,400.00 | 6,400,500.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,374,276.37) | (2,936,846.91) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 122,083,805.00 | 112,083,805.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (51,159,961.44) | (68,381,191.40) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **337,222,031.80** | **336,320,021.20** |
| 39301 | Програм хангамж | 4,180,053.00 | 4,180,053.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (1,858,021.20) | (2,760,031.80) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 334,900,000.00 | 334,900,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **587,709,260.13** | **773,134,045.99** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 587,709,260.13 | 773,134,045.99 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 361,223,069.00 | 361,223,069.00 |
| | Дахин үнэлгээний нөөц | 13,939,962.50 | 13,939,962.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **212,546,228.63** | **397,971,014.49** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 212,546,228.63 | 212,546,228.63 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 185,424,785.86 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **587,709,260.13** | **773,134,045.99** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **404,710,071.00** | **861,613,594.74** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **10,120,371.00** | **315,517,894.74** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,700,000.00 | 13,776,471.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 0.00 | 301,741,423.74 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт | 6,420,371.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **394,589,700.00** | **546,095,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 394,589,700.00 | 546,095,700.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **339,018,615.66** | **667,647,142.12** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **339,018,615.66** | **667,647,142.12** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 115,239,077.50 | 250,467,657.32 |
| 210101 | Үндсэн цалин | 77,995,748.38 | 139,888,444.51 |
| 210102 | Нэмэгдэл | 19,848,184.38 | 79,597,844.21 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,032,000.00 | 4,654,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,075,899.80 | 26,327,368.60 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,287,244.94 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,495,403.10** | **32,254,399.76** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,181,944.34 | 22,376,348.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,165,924.04 | 2,632,511.62 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 878,979.27 | 2,013,609.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 206,232.30 | 475,629.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,062,323.15 | 4,756,299.99 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **6,673,669.00** | **6,517,346.00** |
| 210302 | Түлш, халаалт | 6,233,647.00 | 6,463,380.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 440,022.00 | 53,966.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **5,824,143.00** | **7,976,235.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,166,660.00 | 2,026,860.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,103,293.00 | 2,937,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,611,390.00 | 1,562,055.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | 135,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 165,600.00 | 160,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 717,200.00 | 494,920.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 660,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **481,500.00** | **2,743,850.00** |
| 210604 | Урсгал засвар | 481,500.00 | 2,743,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **828,000.00** | **1,980,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 828,000.00 | 1,980,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,660,917.00** | **2,075,646.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,175,371.00 | 419,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,880,000.00 | 1,062,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 444,700.00 | 433,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 86,646.00 | 86,646.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 19,200.00 | 19,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **138,906,696.29** | **310,535,952.06** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 103,243,581.63 | 274,178,921.94 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 600,000.00 | 170,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 35,063,114.66 | 36,187,030.12 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,000,000.00** | **1,997,417.80** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 1,997,417.80 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **49,909,209.77** | **51,098,638.18** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 49,909,209.77 | 51,098,638.18 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **65,691,455.34** | **193,966,452.62** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **0.00** | **(8,541,666.76)** |
| 225003 | Хөрөнгө оруулалтын гарз | 0.00 | (8,541,666.76) |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 0.00 | (8,541,666.76) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **65,691,455.34** | **185,424,785.86** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **404,710,071.00** | **566,872,171.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **10,120,371.00** | **20,776,471.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 3,700,000.00 | 20,776,471.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт | 6,420,371.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **394,589,700.00** | **546,095,700.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 394,589,700.00 | 546,095,700.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **401,137,571.00** | **560,743,771.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **401,137,571.00** | **560,743,771.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 115,239,077.50 | 257,467,657.32 |
| 210101 | Үндсэн цалин | 77,995,748.38 | 130,700,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 19,848,184.38 | 97,161,201.22 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,032,000.00 | 5,500,000.00 |
| 210104 | Урамшуулал | 9,075,899.80 | 24,106,456.10 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,287,244.94 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,495,403.10** | **32,254,399.76** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,181,944.34 | 26,040,799.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,165,924.04 | 1,553,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 878,979.27 | 1,242,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 206,232.30 | 310,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,062,323.15 | 3,106,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **6,673,669.00** | **6,517,346.00** |
| 210302 | Түлш, халаалт | 6,233,647.00 | 6,463,380.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 440,022.00 | 53,966.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,510,390.00** | **5,857,055.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 800,000.00 | 1,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,799,000.00 | 3,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,611,390.00 | 1,562,055.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 60,000.00 | 135,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 240,000.00 | 160,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **0.00** | **300,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | 300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,131,050.00** | **1,110,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,131,050.00 | 1,110,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **828,000.00** | **1,980,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 828,000.00 | 1,980,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,755,917.00** | **5,848,926.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,270,371.00 | 4,192,780.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,880,000.00 | 1,062,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 444,700.00 | 433,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 86,646.00 | 86,646.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 19,200.00 | 19,200.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **197,594,854.63** | **196,312,330.94** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 196,994,854.63 | 196,142,330.94 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 600,000.00 | 170,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,000,000.00** | **1,997,417.80** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000,000.00 | 1,997,417.80 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **49,909,209.77** | **51,098,638.18** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 49,909,209.77 | 51,098,638.18 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **3,572,500.00** | **6,128,400.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,560,000.00** | **690,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,560,000.00 | 690,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,560,000.00)** | **(690,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 2,012,500.00 | 5,438,400.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 5,088,690.00 | 7,101,190.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 7,101,190.00 | 12,539,590.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **361,223,069.00** | **13,939,962.50** | **212,546,228.63** | **587,709,260.13** |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **361,223,069.00** | **13,939,962.50** | **212,546,228.63** | **587,709,260.13** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **361,223,069.00** | **13,939,962.50** | **212,546,228.63** | **587,709,260.13** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 185,424,785.86 | **185,424,785.86** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **361,223,069.00** | **13,939,962.50** | **397,971,014.49** | **773,134,045.99** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

*/Төгрөгөөр/*

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 | 0.0 |
| 2 | **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **546,095,700.00** | **494,997,061.82** | 90.6 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **546,095,700.00** | **494,997,061.82** | 90.6 |
| 210 | **Бараа, үйлчилгээний зардал** | **544,095,700.00** | **492,999,644.02** | 90.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 257,467,900.00 | 257,467,657.32 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 130,700,000.00 | 130,700,000.00 | 100.0 |
| 210102 | Нэмэгдэл | 103,530,000.00 | 97,161,201.22 | 93.8 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 5,500,000.00 | 5,500,000.00 | 100.0 |
| 210104 | Урамшуулал | 17,737,900.00 | 24,106,456.10 | 135.9 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **34,017,300.00** | **32,254,399.76** | 94.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,803,700.00 | 26,040,799.76 | 93.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,553,300.00 | 1,553,300.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 1,242,700.00 | 1,242,700.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 310,700.00 | 310,700.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,106,900.00 | 3,106,900.00 | 100.0 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **6,586,300.00** | **6,517,346.00** | 99.0 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 70,000.00 | 0.00 | 0.0 |
| 210302 | Түлш, халаалт | 6,246,300.00 | 6,463,380.00 | 103.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 270,000.00 | 53,966.00 | 20.0 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **5,900,000.00** | **5,857,055.00** | 99.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 1,000,000.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 3,000,000.00 | 3,000,000.00 | 100.0 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 1,605,000.00 | 1,562,055.00 | 97.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 135,000.00 | 135,000.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 160,000.00 | 160,000.00 | 100.0 |
| 2105 | **Нормативт зардал** | **300,000.00** | **300,000.00** | 100.0 |
| 210503 | Íîðìûí õóâöàñ çººëºí ýäëýë | 300,000.00 | 300,000.00 | 100.0 |
| 2106 | **Эд хогшил худалдан авах** | **1,800,000.00** | **1,800,000.00** | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 690,000.00 | 690,000.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 1,110,000.00 | 1,110,000.00 | 100.0 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | **1,980,000.00** | **1,980,000.00** | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,980,000.00 | 1,980,000.00 | 100.0 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **5,874,200.00** | **5,848,926.00** | 99.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,200,000.00 | 4,192,780.00 | 99.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,080,000.00 | 1,062,000.00 | 98.3 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 433,300.00 | 433,300.00 | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 86,700.00 | 86,646.00 | 99.9 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 55,000.00 | 55,000.00 | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 19,200.00 | 19,200.00 | 100.0 |
| 2201 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **230,170,000.00** | **180,974,259.94** | 78.6 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 230,000,000.00 | 180,804,259.94 | 78.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 170,000.00 | 170,000.00 | 100.0 |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,000,000.00** | **1,997,417.80** | 99.9 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,000,000.00 | 1,997,417.80 | 99.9 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 2,000,000.00 | 1,997,417.80 | 99.9 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 546,095,700.00 | 494,997,061.82 | 90.6 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 546,095,700.00 | 494,997,061.82 | 90.6 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 546,095,700.00 | 494,997,061.82 | 90.6 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Иргэдийнхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм эдийн засгийн хөгжлийг ногоон баримжаатайгаар байгаль орчны тэнцвэрт байдалтай уялдуулах, байгаль орчныг хамгаалах, түүний нөөц баялгийг зохистой ашиглах, жам ёсоороо нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэхэд орон нутгийн удирдлага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, санаачилгыг чиглүүлэх, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан ажиллах" гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:

- Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- Ойн нөөцийг хамгаалах, "Тэрбум мод" хөдөлгөөнийг өрнүүлж, хэрэгжилтийг хангах
- Усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, дасан зохицох, усны нөөцийг зохистой ашиглаж хамгаалах
- Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 12 зорилтын хүрээнд 141 арга хэмжээг төлөвлөж, 95 хувийн биелэлттэй тайлагнасан ба БОАЖС, аймгийн Засаг даргын байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 9 зорилтын хүрээнд 57 арга хэмжээг хэрэгжүүлж 91.0 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

2023 оны нийт зардлын санхүүжилтийн эх үүсвэр төлөвлөснөөр 546,095.7 мянган, гүйцэтгэл 494,997.1 мянган төгрөг буюу 90.6 хувийн биелэлттэй байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2022 оны 192 дүгээр тогтоол ;
- Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол “Автомашин ашиглалтын тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага дотоод хяналтын чиг үүргийг газрын даргын тушаалаар батлагдсан журам зааврыг мөрдлөг болгодог. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг засаж, зөвлөмжийг биелүүлэн ажилласан тул байгууллагын дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар түүнийг аудитад ашиглахгүй гэж үзлээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус аймгийн хэмжээнд нийтлэг мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байгаа нь зарим нэг хууль тогтоомжийн өөрчлөлтийг эс тооцвол нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тус газар 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 185,424.8 мянган төгрөгөөр буюу 31.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 7,101.2 | 12,539.6 | 5,438.4 |
| Бараа материал | 58,322.3 | 78,317.0 | 19,994.7 |
| Бусад эргэлтийн хөрөнгө нөөц | 93,622.0 | 0.0 | -93,622.0 |
| Үндсэн хөрөнгө | 428,663.7 | 682,277.4 | 253,613.7 |
| **Нийт хөрөнгө** | **587,709.2** | **773,134.0** | **185,424.8** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 587,709.2 | 773,134.0 | 185,424.8 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **587,709.2** | **773,134.0** | **185,424.8** |

Дээрх хүснэгтээс харахад, дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 5,438.4 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн сангийн хэмнэлтээс ахмадын санд 7,000.0 мянган төгрөгийг Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу шилжүүлсэнтэй холбоотой;
- Бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 19,994.7 мянган төгрөгөөр өссөн нь үндсэн хөрөнгөөс эргэлтийн хөрөнгөд шилжүүлсэнтэй холбоотой;
- Бусад эргэлтийн хөрөнгө нөөц дансны үлдэгдлийн өөрчлөлт 93,622.0 мянган төгрөгөөр буурсан нь БХНСАХЗ-аар хийсэн ажлууд бүртгэлтэй байсныг аймгийн ИТХ-ын 2023 оны 11 дүгээр тогтоолоор ашиглагч байгууллагуудад шилжүүлсэнтэй холбоотой;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 253,613.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Сүмбэр сумын ЗДТГ-аас балансаас балансад 281,374.1 мянган төгрөгийн өртөгтэй конторын барилга шилжүүлэн авсантай холбоотой;
- Засгийн газрын хувь оролцоо дансны өөрчлөлт 185,424.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө шилжин ирсэнтэй холбоотой.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 238,181.9 мянган, үйл ажиллагааны орлогоос 229,000.0 мянган нийт зарлагыг 467,181.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг орон нутгийн төсвийг 59,113.8 мянган, үйл ажиллагааны орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 527,295.7 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тайлант онд мөрдөгдөх хуулийн заалтад өөрчлөлт орсон нь нөлөөлсөн байна.

Төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь тайлант хугацааны төсвийн төсөлтэй уялдаж, Төсвийн тухай хуульд заасан төсвийн шаардлагад нийцсэн байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг орон нутгийн төсвийг 18,800.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн төсвийг 316,095.7 мянган, өөрийн орлогыг 230,000.0 мянган нийт 546,095.7 мянган төгрөгөөр төсөв захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр тодотгосон байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 314,192.8 мянган, үйл ажиллагааны орлогоос 180,804.3 мянган нийт 494,997.1 мянган төгрөгийг төвлөрүүлэн 90.6 хувийг зарцуулсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт хийгдээгүй.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийн хүрээнд 40,522.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч орлогоор бүртгэсэн.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, чанарын менежер Г.Цогтбаатар нар гүйцэтгэж, хяналтыг захирал М.Буянбулган болон Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 21 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн нийт зардлын 339,018.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 3,390.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Учир нь 2023 онд зарим эрх зүйн актуудад өөрчлөлт орсонтой холбоотой төсөв болон гүйцэтгэл нэмэгдсэнтэй холбоотой болно.

Аудитын явцад материаллаг байдлыг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.0 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 6,676.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай 32 заалтын хэрэгжилтэд аудитын горим, сорил гүйцэтгэхээр төлөвлөж, хяналтыг хэрэгжүүлэв. Байгууллага төсвийн үргүй зардал гаргахгүй байх, батлагдсан төсвийг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Хуулийн хүрээнд төсвийн хэмнэлтийг авч үзэхэд нийт урсгал зардал 51,098.6 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна. Үүнд цалингийн нэмэгдэл урамшуулал 6,368.6 буюу ажил олгогчоос нийгмийн даатгал төлөх шимтгэл 1,762.9 мянган, байр ашиглалтын зардал 69.0 мянган, хангамж, бараа материалын зардал 43.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардлыг 49,195.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан нь нөлөөлжээ.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорил хэрэгжүүлэхэд материаллаг зөрчил илрээгүй.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Үндэсний аудитын газраас зарласан сонгон шалгаруулалтаар Говьсүмбэр аймгийн багц 1-д тэнцэж, гурвалсан гэрээг 2023 оны 10 дугаар сарын 13-нд байгуулж, аудитын нээлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газартай шалгагдагч байгууллагуудын удирдлага, нягтлан бодогчдыг оролцуулан хийв. Завсрын аудитыг эхний 9 сарын санхүүгийн болон холбогдох баримт, байгууллагын үйл ажиллагаатай биечлэн танилцах ажилбаруудыг гүйцэтгэж, илэрсэн алдаа, зөрчлийн асуудлыг байгууллагын удирдлагад танилцуулж, уулзалтын тэмдэглэлээр баримтжуулсан.

Асуудлын бүртгэлийг жилийн дүнгээр нэгтгэн танилцуулж шийдвэрлүүлэхээр тогтсон болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон албан шаардлагын хэрэгжилтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 230 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | - | - | - | - | - |
| Албан шаардлага | 1 | 357.9 | 1 | 357.9 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | 49,538.3 | 1 | 49,538.3 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Нийт дүн** | **2** | **49,895.2** | **2** | **49,895.2** | **100.0** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Агнуурын дуудлага худалдааны болон байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрт анхаарах

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар жолоочийн тооцооны хүснэгтийн явсан замын бичвэрийн тэмдэглэл тодорхой бус байсан алдаа[1] илэрсэн бөгөөд зөрчил дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

### 5.1 Зөвлөмж

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Жолоочийн тооцооны хүснэгтийн явсан замын бичвэрийн тэмдэглэл тодорхой бус байсан алдаа илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалт, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан журмын тухайн маягтуудыг хөтлөх, гүйцэтгэлд хяналт тавих зааврыг мөрдлөг болгоогүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Жолоочийн тооцооны хүснэгтийг зааврын дагуу бүрэн бөглөх, явсан замын тэмдэглэлийг тодорхой, үнэн зөв бүрэн бичих

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Дотоод хяналт | 1 | 0.0 | - | - | - | - | 1 | 0.0 |
| Дүн | 1 | 0.0 | - | - | - | - | 1 | 0.0 |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ**

**Байгууллагын нэр:** Говьсүмбэр аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар
**Тайлант хугацаа: 2023.01.01-2023.12.31**
**Байгууллагын РД: 9019197**

Аудитын код: ГСА-2024/46/НА-СТА-ТШЗ
Аудитын нэр: Говьсүмбэр аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар
Тайлант хугацаа: 2023.01.01-2023.12.31

/ төгрөгөөр /

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| A | 1 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| **1. Нийцлийн аудитын асуудлын бүртгэл** | | | | | | | | | |
| 1 | Бараа материал | Жолоочийн тооцооны хүснэгтийн явсан замын бичвэрийн тэмдэглэл тодорхой бус байсан. | 0.0 | Зөвлөмж өгөх | | | Зөвлөмж өгөх | Дарга<br>Нягтлан бодогч | М.Мөнх-Эрдэнэ<br>Ц.Цэрэнчимэд |

Бэлтгэсэн: Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн

Захирал М.Буянбулган Огноо:

Хянасан: Аудитын менежер Г.Наранбаяр Огноо:

Хянасан: Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Огноо:

Танилцаж зөвшөөрсөн:

Дарга Д.Мөнх-Эрдэнэ Огноо: 2023-02-06

Нягтлан бодогч Ц.Цэрэнчимэд Огноо: 2023-02-06